

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 29

Арвайхээр

Аймгийн хөдөлмөр аюулгүй байдал,
эрүүл ахуйн дэд хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс үе шаттай санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан явц, үр дүнг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

100130059

C:\My Documents \Nuuts.Togtool.doc

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
/2019-2021 он/**

Нэг. Үндэслэл

Манай улс 2008 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуультай болсноор хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх төрийн бодлогыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийг 1997 оноос үе шаттайгаар тасралтгүй хэрэгжүүлж ирсэн бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн дөрөв дэх хөтөлбөр (2012-2016) хэрэгжих хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэдээлэл, сурталчилгааны тогтсон арга хэлбэрийг төлөвшүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзүүлэх сургууль зохион байгуулах, аймаг, сумдын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дөрөвдэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд 13 үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэнээс 15 хүн осолд өртөж, 2 хүн амь насаа алдсан байна. Үүний 77 хувь төрийн байгууллагад, 15.4 хувь нь төрийн өмчит хувьцаат компанид, 7.6 хувь нь хувийн хэвшилд гарсан осол байна. Эдгээр ослуудын 53.8 хувь нь аюулгүй ажиллагаа хангаагүйгээс, 23.0 хувь нь зам тээврийн ослоын улмаас, 23.2 хувь нь анхаарал болгоомжгүйгээс үүссэн байна. Мөн Татварт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оноос 9.2 хувь буюу 170-аар нэмэгдсэн байна. Тухайлбал Төрийн байгууллага 2, ХХК 87, төрийн бус байгууллагууд 52, хоршоо 3, салбар 21-ээр тус тус нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд жилээс жилд аж ахуйн нэгж, байгууллагын тоо нэмэгдэж байгаа боловч эдгээрээс:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгж, бүтэцтэй- 8
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй /20-иос дээш ажилтантай/-55
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай – 223
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх байнгын комисстой /9-өөс дээш ажилтантай/- 41 тус тус ажиллаж байна.

Дээрх тоо мэдээллээс үзэхэд эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны соёл, дадал заншлыг ажилтан бүрт эзэмшүүлэхэд анхаарч, ажил олгогчдын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр эрх зүйн орчин хэдийгээр бүрдсэн ч аж ахуйн нэгж, байгууллагууд мөрдөж хэвшүүлэхгүй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал хангалтгүй, хуулийн дагуу төсөв төлөвлөж зарцуулдаггүй, ялангуяа төсвийн байгууллагууд дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилладаггүй зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/210 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2017-2020 он/-ний 1.3.1, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ" хөтөлбөрийн 3.4.2.2 зорилтыг тус тус дэвшүүлсэн бөгөөд нэн тэргүүний хэрэгцээ шаардлага болоод байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах, ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн,

4.2.6. Цацраг идэвхит бодис, хими биологийн орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад стандартыг мөрдүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сайжруулах

4.3. Гуравдугаар зорилтын хүрээнд:

4.3.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, мэргэшсэн ажилтны судалгаа хийж, мэдээллийн санг бүрдүүлэх

4.3.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, статистик мэдээллийн санг боловсронгуй болгох

4.3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм зөрчсөн, осол аваар гаргасан байгууллага аж ахуйн нэгжид холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

4.3.4. Үйлдвэр үйлчилгээ, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад жилд 2 удаа тогтмол хяналт шалгалтыг зохион байгуулах, хариуцлага тооцох

Тав. Хөтөлбөрийн зарчим

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

5.1.1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх;

5.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх байнгын хяналтын тогтолцоог хангах;

5.1.3. Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх;

5.1.4. Нийгмийн түншлэлийг эрхэмлэх;

5.1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангах;

5.1.6. Эрсдэлтэй бүлэгт түлхүү анхаарах;

5.1.7. Салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

5.1.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлийг бүрдүүлсэн байх;

Зургаа. Хугацаа, Санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

Үүнд:

6.2.1. Улсын болон орон нутгийн төсөв

6.2.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл хөтөлбөрийн санхүүжилт

6.2.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах хөрөнгө

6.2.4. Бусад эх үүсвэр

Долоо. Үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

7.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, сургалт мэдээллийн шинэлэг арга хэлбэрт шилжсэнээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах зан үйл төлөвшиж, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин буурсан байна.

7.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг аж ахуйн нэгж байгууллага, ажилтны түвшинд ханган ажиллахад ажил олгогч, ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтан бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрддөг, ажилтнуудад өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв хандлага төлөвшсөн байна.

7.1.3. Аж ахуйн нэгж, байгууллага бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо боловсронгуй болж, салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагаа төлөвшиж, хамтын ажиллагаа сайжирсан байна.

7.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн статистик мэдээллийн систем, тогтолцоог боловсронгуй болгож, судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлсэн байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2017/	Зорилтот түвшин, он			Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх
				2019	2020	2021		
Нэг. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар:								
1	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо	/10.000 ажиллагсдад ногдох/	13	70 хувь	60 хувь	50 хувь	МХГ	ХХҮГ
2	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас нас барагсдын тоо	/10.000 ажиллагсдад ногдох/	2	-	-	-	МХГ	ХХҮГ
Хоёр. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага:								
3	Аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт	Тоо	50	60	70	80	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, ХХҮГ	МХГ, АОЭХ, ҮЭХ
Гурав. Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ :								
4	Хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан сургалт	Тоо	10	15	20	25	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд
5	Хууль тогтоомжийг сурталчлан таниулах арга хэмжээ	Тоо	1	2	3	4	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургагч багш бэлтгэх	Тоо	5	10	12	15	ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд
Дөрөв. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага								
7	ХАБЭА-н ажилтантай байгууллага	Тоо	223	300	350	400	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ	ААНБ-ууд
8	ХАБЭА-н зөвлөлтэй байгууллага	Тоо	55	60	65	65	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ	ААНБ-ууд
9	ҮОХХСБК-той байгууллага	Тоо	41	45	50	55	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ	ААНБ-ууд
10	ҮОХХСБК-той сум	Тоо	12	15	19	19	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ	ААНБ-ууд
Зургаа. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар:								
11	МШӨ-өөр хөдөлмөрийн чадвар алдсан иргэд	/10.000 ажиллагсдад ногдох/	50	50	50	50	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд
12	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн байгууллага	Тоо	35	45	50	55	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, МХГ, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд
13	Хамтын гэрээ байгуулсан байгууллага	Тоо	8	12	17	20	Аймгийн ХАБЭА-н зөвлөл, ХХҮГ, АОЭХ, ҮЭХ	ААНБ-ууд

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүргийг Өвөрхангай аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хамтран хэрэгжүүлнэ.

8.2. Өвөрхангай аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвтөө тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоолын дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.3. Аж ахуйн нэгж, байгууллага бүр энэхүү хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг жил бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тайланг ирүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жилд 1 удаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээ, тайланг тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй мэдээлнэ.